



OSH Academy
Occupational Safety & Health Training



**МОНГОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ЭРҮҮЛ АХУЙН
МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭЛЭН**

Дэлхийд өрсөлдөх Монгол компанийн төлөө!

ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА (КУРС-700)



ӨМНӨХ ҮГ

Эрхэм суралцагч таны энэ өдрийн амгаланг эрж мэндчилье!

Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990 оноос үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулах компаниуд олноор бий болж тэнд ажиллагсдын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. 2008 онд Монгол улс түүхэндээ анх удаа ХАБЭА-н тухай бие даасан хуультай болж аж ахуйн нэгж байгууллагуудын эзэд, ажил олгогчид, төрийн байгууллагуудын зохион байгуулалт, удирдлага хяналтын тогтолцоо, тэдгээрийн ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, эрх, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг тодорхойлж өгсөн.

Аж ахуйн нэгж байгууллагуудын тоо нэмэгдсэнээр /ялангуяа уул уурхай, барилгын салбарт/ үйлдвэрлэлийн ослоор амь насаа алдах, хөдөлмөрийн чадвар алдах болон хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол гарсаар байна. Үйлдвэрлэлийн осол гарч байгаад нөлөөлж буй гол хүчин зүйл нь Монгол эзэдтэй аж ахуйн нэгжүүдэд ХАБЭА-н удирдлагын тогтолцоо нэвтрүүлж, байгууллагын менежмент ба засаглалыг сайжруулах хэрэгцээ байгаатай холбоотой юм.

Иймд, манай хүрээлэн нийгэмд үйлчлэх чиг үүрэгтэй төрийн бус байгууллагын хувьд дотоодын ХАБЭА-н сургалтыг олон улсын түвшинд хүргэж нийгэмд хувь нэмэр оруулах зорилго тавин ажиллаж байна. Энэ зорилгоор манай хамт олон АНУ-д төвтэй, дэлхийн 50 гаруй оронд бие даасан сургагч байгууллагатай, ХАБЭА-н олон улсын сургалтын байгууллага болох OSHAcademy-н Монгол Улс дахь бие даасан сургагч байгууллагаар шалгарч, Монголд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд болон тэдгээрт ажиллаж байгаа ХАБЭА-н ажилтнуудад дэлхийн боловсролын чиг хандлагыг тодорхойлогч Америкийн ХАБЭА-н боловсролыг Монголдоо эзэмших боломж олгож байна.

Та энэхүү гарын авлагаас олж авсан мэдлэгээ Монгол Улсынхаа хууль тогтоомжтой уялдуулан хэрэгжүүлэх учиртай юм. ХАБЭА-н ажилтны мэргэжлийн мэдлэг ур чадвар нь компанийн, цаашилбал улс эх орны хөгжилд чухал ач холбогдолтой цагаан мөртөй ажил байдаг. Энэхүү сургалтыг төгссөнөөрөө таны ХАБЭА-н онолын болоод практик мэдлэг чадвар сайжирна гэдэгт бид эргэлзэхгүй байна. Таны монгол хүний амь нас эрүүл мэндийн төлөө хийж байгаа цаашид хийх ажилд тань өндөр амжилт хүсэн ерөөе!

Сургалтаар олгогдсон мэдлэгийг ажилд хэрэгжүүлэх явцад танд ямар нэг бэрхшээл тохиолдвол бид зөвлөгөө өгөх, хамтран ажиллахдаа баяртай байх болно. Түүнчлэн та гарын авлага болон сургалтын талаарх санал, шүүмжээ training@oshmi.mn хаягаар ирүүлээрэй!

Таныг хүндэтгэсэн:

Монголын Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа, Эрүүл Ахуйн
Менежментийн Хүрээлэнгийн Үүсгэн байгуулагч

Д.Батбаатар

АГУУЛГА

МОДУЛЬ 1. ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.....	5
Модуль 1.1. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо гэж юу вэ?	5
Модуль 1.2. Яагаад ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ёстой вэ?	6
Модуль 1.3. ХАБЭА-н удирдлагын тогтолцооны 7 элемент	7
МОДУЛЬ 1. ШАЛГАЛТ.....	9
МОДУЛЬ 2. ДЭЭД УДИРДЛАГЫН ҮҮРЭГ АМЛАЛТ БУЮУ ХАНДЛАГА	10
Модуль 2.1. Яагаад удирдлагууд үүрэг амлалт авах ёстой вэ?.....	10
Модуль 2.2. Яагаад удирдлагуудын үүрэг амлалт, хандлага өөр өөр байдаг вэ?	12
Модуль 2.3. Тэгвэл яаж муу хандлагыг өөрчлөх вэ?	14
Модуль 2.4. Яагаад компаниудын ХАБЭА-н соёл өөр өөр байдаг вэ?	15
МОДУЛЬ 2. ШАЛГАЛТ.....	18
МОДУЛЬ 3. ӨӨРИЙГӨӨ ЗӨВШӨӨРҮҮЛЭХ НЬ БУЮУ ХАРИУЦЛАГА.....	19
Модуль 3.1. Гүйцэтгэлд тавих албан ёсны стандарт	19
Модуль 3.2. Нөөц, ажил амралтын горим.....	19
Модуль 3.3. Гүйцэтгэлийг хэмжих тогтолцоо.....	20
Модуль 3.4. Үр дагаваргүй үйлдэл гэж байдаггүй.....	20
Модуль 3.5. Шударга, тохирсон арга хэмжээ авах	21
Модуль 3.6. Хариуцлагын тогтолцоог тасралтгүй үнэлэх	22
МОДУЛЬ 3. ШАЛГАЛТ.....	23
МОДУЛЬ 4. ХАБЭА-Н АЖИЛД АЖИЛТНЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ.....	24
Модуль 4.1. Яаж ХАБЭА-н шаардлагыг биелүүлж ажилладаг болгох вэ?	24
Модуль 4.2. Яаж ажилтнуудыг аюулыг мэдээлдэг болгох вэ?	25
Модуль 4.3. Яаж шагналыг үр дүнтэй болгох вэ?.....	25
Модуль 4.4.“Сайныг хийх гээд мууг дэмжиж болохгүй”	26
МОДУЛЬ 4. ШАЛГАЛТ.....	27
МОДУЛЬ 5: ҮР ДҮНТЭЙ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА МАШ ЧУХАЛ	28
МОДУЛЬ 5. ШАЛГАЛТ.....	29
МОДУЛЬ 6. АЮУЛЫГ ИЛРҮҮЛЭХ БА ХЯНАЛТ	30

Модуль 6.1. Ажлын байрны аюулын таван төрөл	30
Модуль 6.2. Аюулыг хянах шатлал	31
Модуль 6.3. Ажлын аюулын шинжилгээ	32
МОДУЛЬ 6. ШАЛГАЛТ	33
МОДУЛЬ 7: ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ СУДЛАХ.	34
Модуль 7.1. Буруутныг олох биш тогтолцоогоо зас!	34
Модуль 7.2. Осолд дөхсөн тохиолдол ба ослыг судлах нь	34
Модуль 7.2.1. Осолд бэлэн байх	34
Модуль 7.2.2. Осол болсон ажлын байрыг тусгаарлаж хамгаалалтанд аваарай.	35
Модуль 7.2.3. Осол болох хүртэлхи үйл явдлын дэс дарааллыг тогтооно.	35
Модуль 7.2.4. Гадаад шалтгааныг тодорхойлно.	35
Модуль 7.2.5. Үндсэн шалтгааныг тогтооно.	36
Модуль 7.2.6. Ослын акт, зөвлөмж бичих	36
МОДУЛЬ 7. ШАЛГАЛТ	37
МОДУЛЬ 8: ХАБЭА-Н БОЛОВСРОЛ ОЛГОХ, СУРГАХ	38
Модуль 8.1. ХАБЭА-н боловсрол ба сургалт	38
Модуль 8.2. Ажлын байран дээрх 7 алхамт сургалтын үйл явц	39
МОДУЛЬ 8. ШАЛГАЛТ	40
МОДУЛЬ 9. ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭ	41
МОДУЛЬ 9. ШАЛГАЛТ	42

МОДУЛЬ 1. ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ


Модуль 1.1. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо гэж юу вэ?

ХАБЭА-н удирдлагын тогтолцоог энгийн үгээр илэрхийлвэл: “Байгууллагынхаа ажлын байрыг эрүүл, аюулгүй байлгаснаар ажилтнуудынхаа сэтгэл ханамж, тогтвор суурьшил, бүтээмжийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл гаргахгүй байхын тулд ХАБЭА-н бодлого зорилтоо тодорхойлж, түүнд хүрэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах талаар хийгддэг ажлуудын цогцыг хэлнэ” гэж ойлгож болох юм.

ХАБЭА-н удирдлагын тогтолцоог байгууллага дээрээ хэрэгжүүлэхдээ MNS ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх заавар” стандартын шаардлагын дагуу хэрэгжүүлнэ.

Уг стандартаар аж ахуйн нэгж, байгууллагууд ХАБЭА-н удирдлагын тогтолцоог ТӨЛӨВЛӨ (Plan) –ХИЙ (Do) –ШАЛГА (Check) –САЙЖРУУЛ (Act) буюу PDCA загвараар хэрэгжүүлэх шаардлагыг тусгасан байдаг.

Өөрөөр хэлбэл:



- 1.ХАБЭА-н ажлыг заавал төлөвлөх ёстой.
2. ХАБЭА-н бүх ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжих ёстой.
- 3.Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байгаа ХАБЭА-н ажлын үр дүнг үнэлдэг байх ёстой.
- 4.Үнэлгээнээс гарсан үл тохирол буюу алдаа дутагдлыг засч залруулдаг байх ёстой гэсэн шаардлага тавигддаг.

Стандартад эдгээр шаардлагыг хангахын тулд ямар ажлууд хийх ёстойг тодорхойлж өгсөн байдаг.

Модуль 1.2. Яагаад ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ёстой вэ?

1. Хуулийн шаардлага

Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийн 27.2-р зүйлд аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг /үүнийг ХАБЭА-н ажилтан эсвэл алба, хэлтэс, газар болон ХАБЭА-н асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл гэж ойлгоно/. Үүнд:

- 27.3.1-д: Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;
- 27.3.2-д: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.


Ийм учраас ХАБЭА-н удирдлагын тогтолцоог компани дээрээ хэрэгжүүлнэ гэдэг нь сайн дурын ажил буюу сонголт биш бөгөөд ХАБЭА-н ажилтны хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг гэж ойлгож болно.

2. Бизнесийн шаардлага

Манай оронд хэрэгжиж байгаа томоохон төслүүдэд манай үндэсний компаниуд тэргүүлэн оролцож чадахгүй, зөвхөн туслан гүйцэтгэгчийн түвшинд ажиллаж, боломжит ашгийг олж чадахгүй алдаж байна.

Ийм учраас манай үндэсний компаниуд цаашдаа хөгжих, тогтвортой үйл ажиллагаа явуулах, гадаад зах зээлд хүч үзэн өрсөлдөх хүсэл эрмэлзэлтэй байгаа бол захиалагч хэрэглэгчдийн зүгээс тавьж буй Чанар, Хөдөлмөрийн эрүүл мэнд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Байгаль орчны гүйцэтгэлтэй холбогдолтой шаардлагыг хангахын тулд Чанар, ХАБЭА, Байгаль орчны удирдлагын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх, тогтмолжуулах зайлшгүй шаардлагтай байгаа юм.

Модуль 1.3. ХАБЭА-н удирдлагын тогтолцооны 7 элемент



1.ХАБЭА-н удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд компанийн дээд удирдлагын үүрэг амлалт буюу тэдний хандлага, манлайлал хамгийн чухал гэж үздэг. Ийм учраас энэ хичээлээр ажил олгогчдын ХАБЭА-д хандах хандлагыг хэрхэн өөрчилж тэднээр хүчтэй бөгөөд бодит үүрэг амлалт авахуулах талаар үзэх юм.

2. ХАБЭА-н удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд нийт ажилтнуудын ХАБЭА-н талаар хүлээх үүрэг хариуцлага, эрх мэдлийг тодорхой болгож өгөх шаардлагатай байдаг.

Өөрөөр хэлбэл ХАБЭА-н удирдлагын тогтолцоо зөвхөн ХАБЭА-н ажилтны хүлээх үүрэг хариуцлага биш, нийт ажилтны үүрэг хариуцлага болж байж хэрэгжих боломжтой гэсэн үг юм. Жишээ нь: Хангамжийн ажилтан аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй багаж хэрэгсэл нийлүүлснээс үүдэж, түүнийг нь хэрэглэж байсан ажилтан гэмтэж бэртвэл хангамжийн ажилтан хариуцлага хүлээдэг байх ёстой. Тийм учраас хангамжийн ажилтны ажлын байрны тодорхойлолтонд аюулгүй ажиллагааны талаар ямар үүрэг хариуцлага хүлээх, мөн ямар эрхтэй байхыг тусгаж өгөх шаардлагатай гэсэн үг юм. Мөн ахлах ажилтнууд өөрийн удирдлага хяналтанд байгаа ажилтнуудаа хянахгүй бол мөн л осол гарах магадлал өндөр байна.Тийм учраас ахлахууд хариуцаж байгаа ажилтнуудаа сургах, хянах үүрэг хүлээж ажиллана гэсэн үг.

Энэ талаар Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Австрали гэх зэрэг ХАБЭА-н хөгжил өндөр түвшинд хүрсэн орнуудад Professional Due Care буюу Мэргэжлийн Ажилтнуудын Анхаарал Болгоомжтой Байх Үүрэг гэдэг нэртэй хуулийн шаардлага гаргасан байдаг ба үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд судалгаа хийхдээ, ямар ажилтны буруутай үйлдэл, эс үйлдлээс шалтгаалсан бэ гэдгийг тогтоож, хариуцлага хүлээлгэдэг.

3. Компани бүх ажлын байран дээр ажилтныг бэртээж гэмтээх ямар аюулууд байгаа вэ? Тэдгээрийн осол болох магадлал нь хир зэрэг вэ? гэдгийг үнэлж, түүнийг хянах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, ажлын үеэр тогтмол хянаж, арга хэмжээ авч байх ёстой гэсэн шаардлага байдаг.

4. ХАБЭА-н тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ХАБЭА-н сургалт байдаг. ХАБЭА-н хууль болон стандартаар компанийн бүх ажилтнууд ажлаа аюулгүй гүйцэтгэх арга барил эзэмшсэн буюу маш сайн сургагдсан байх ёстой гэсэн шаардлага байдаг. Өөрөөр хэлбэл, аюулгүй ажиллагаанд ажилтнуудын мэргэжил боловсрол, туршлагад дан найдахаас илүү бүх ажилтан аюулгүй ажиллах арга барил эзэмшсэн байх ёстой гэдэгт илүү анхаардаг.

5. Ажлын байранд ямар ч үйлдвэрлэлийн осол, онцгой байдал үүсэхэд ямар хариу арга хэмжээ авах вэ? гэдгээ тодорхойлсон, түүнд бэлэн байх ёстой гэсэн шаардлага байдаг. Өөрөөр хэлбэл, байгууллагад үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисс, онцгой байдал үүссэн үед ажиллах журам, төлөвлөгөөтэй байх ба тухайн комиссын бүрэлдэхүүнд орсон ажилтнууд нь маш сайн сургагдсан байх хэрэгтэй.

6. ХАБЭА-н удирдлагын тогтолцоондоо тодорхой давтамжтайгаар аудит хийж, тогтолцоогоо үнэлж байх ёстой гэсэн шаардлага байдаг. Энэ нь ХАБЭА-н хяналт шалгалт биш бөгөөд хэрэгжүүлж байгаа ХАБЭА-н тогтолцоо үр дүнтэй байна уу, үгүй юу, аль хэсэг нь сайн ажиллаад, аль хэсэг нь тааруухан байгаа, яаж сайжруулах шаардлага хэрэгцээ байгаа юм бэ гэдгийг илрүүлж, тодорхойлох, сайжруулах хэрэгцээг үнэлэх үйл явц байх юм.

7. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо амжилттай хэрэгжихэд ажилтнуудын идэвхитэй оролцоо хамгийн чухал байдаг. Өөрөөр хэлбэл, эрсдлийн үнэлгээнд ажилтнуудыг оролцуулахгүй бол ажлын байран дахь аюулуудын ихэнхи хэсгийг илрүүлж чадахгүй. Яагаад гэвэл, бүх ажлын байрыг тэд л хамгийн сайн мэддэг, мэдэрсэн байдаг. Ажилтнуудыг ажилтнууд л сургаж чадна. Яаж ажлаа аюулгүй гүйцэтгэхийг туршлагатай буюу ахлах ажилтан л хамгийн сайн хэлж чадна. Тийм учраас ажлын байрны шалгалт, сургалт, эрсдэлийн үнэгээнд ажилтнуудын оролцоо №1 ач холбогдолтой байдаг.

МОДУЛЬ 1. ШАЛГАЛТ

1. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо гэж.....ХЭЛНЭ
 - а/ ХАБЭА-н сургалт явуулж, эрсдэлийн үнэлгээ хийж, аюулыг хянахыг
 - б/ ХАБЭА-н бодлого зорилтоо боловсруулж, баталж, хэрэгжүүлэхийг
 - в/ ХАБЭА-н төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэхийг
 - г/ ХАБЭА-н ажлаа тогтмол үнэлж, сайжруулахыг
 - д/ Дээрх бүгд
2. ХАБЭА-н удирдлагын тогтолцооог ямар загвараар хэрэгжүүлдэг вэ?
 - а/ Төлөвлө- хий- шалга
 - б/ Хий – шалга – төлөвлө- сайжруул
 - в/ Төлөвлө –хий – шалга – сайжруул
 - г/Төлөвлө –хий –сайжруул –шалга
3. ХАБЭА-н удирдлагын тогтолцоог яагаад заавал хэрэгжүүлэх ёстой вэ?
 - а/ Ажилтнуудаа осолд өртүүлэхгүйн тулд
 - б/ Хуулиар шаарддаг учраас
 - в/ Стандартаар шаарддаг учраас
 - г/ Тендерт ороход хэрэгтэй бйдаг учраас
4. ХАБЭА-н сургалтын зорилго болЮМ
 - а/ Ажлаа яаж хийхийг нь мэдүүлэх
 - б/ Осолд өртүүлэхгүйн тулд
 - в/ Ажлаа аюулгүй хийх арга барил эзэмшүүлэх
 - г/ Ажлын бүтээмжийг дээшлүүлэхийн тулд
5. ХАБЭА-н аудитын зорилго нь.....ЮМ
 - а/ ХАБЭА-н тогтолцооныхоо алдааг олж залруулах
 - б/ ХАБЭА-н тогтолцоог шалгаж дүгнэх
 - в/ Хэн ажлаа муу хийгээд байгааг илрүүлэх